



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

“Захиалагчийн алба” орон нутгийн өмчит
аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус дүүргийн “Захиалагчийн алба” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж хавсралт ёсоор баталсугай.
2. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлж, бүтэц, орон тоог баталж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д даалгасугай.



ДАРГА

Б.МӨНХЦЭЦЭГ

1180100085

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн
... 1/29 дугаар тогтоолын хавсралт

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН “ЗАХИАЛАГЧИЙН АЛБА” ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗЫН ДҮРЭМД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1. “Захиалагчийн алба” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрын дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:**

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. дэх хэсгийг Сонгинохайрхан дүүргийн захиалагчийн алба /цаашид Алба гэх/орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд улс, нийслэл, дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, зээл, тусламж, Төрийн ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх ажлууд, төсөл арга хэмжээнүүдийн ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, захиалагчийн хяналтыг Захиалагч болох Засаг даргын Тамгын газар /цаашид Захиалагч гэх/-ын өмнөөс мэргэжлийн чиг үүргээр хэрэгжүүлэх, инженерийн хяналт тавих, улсын комиссын үйл ажиллагааг зохион байгуулах, улсын комиссын акт, гэрээг дүгнэн баталгаажуулах, хатуу түлш тээвэрлэх, борлуулах, ахуйн шавьж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх, бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ, нохой, муур устгах, гудамж, зам талбай засварлах, сэргээх үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий иргэний гүйлгээнд ордог орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн гэж өөрчлөх.

1.2. дахь хэсгийг Алба нь Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, Иргэний хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Барилгын тухай хууль, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоол, Барилгын норм ба дүрэм, Засаг даргын захирамж, холбогдох хууль тогтоомжууд болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна гэж өөрчлөх

1.3 дахь хэсгийг Энэхүү дүрмийн зорилго нь Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн алба”-ны үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, албаны эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино гэж өөрчлөх

Хоёрдугаар хэсэгт Удирдлага зохион байгуулалт гэснийг
Албаны оноосон нэр, оршин байгаа газар гэж өөрчлөх

2.1 дэх хэсгийг Газрын оноосон нэр: Монголоор Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн алба” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байна гэж өөрчлөх

2.2 дахь хэсгийг Газрын оршин байгаа газар нь: Сонгинохайрхан дүүрэг 6 дугаар хороо гэж өөрчлөх

2.3 дахь хэсгийг Газрын шуудангийн хаяг: гэж өөрчлөх

2.4 дэх хэсгийг Вэб сайт: гэж өөрчлөх

2.5 дахь хэсгийг Электрон шуудангийн хаяг: гэж өөрчлөх

Гуравдугаар хэсэгт Албаны үүрэг гэснийг Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн алба”-ны бэлгэдэл, тэмдэг гэж өөрчлөх

3.1 дэх хэсгийг Алба нь өөрийн бэлгэдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ гэж өөрчлөх.

3.2 дахь хэсгийг Тэмдгээр албаны албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна гэж өөрчлөх.

3.3 дахь хэсгийг Тэмдгийг захирал, түүнээс итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцна гэж өөрчлөх.

Дөрөвдүгээр хэсэгт Албаны эрх гэснийг Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн алба”-ны зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх, үүрэг гэж өөрчлөх

4.1 дэх хэсгийг Алба нь дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх бүх хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын гэрээ хийж, инженерийн хийцтэй барилга байгууламж, тохижилт, бүх төрлийн зам зэрэг ажлуудад Захиалагч, дүүргийн Худалдан авах ажиллагааны алба, иргэдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хатуу түлш тээвэрлэх борлуулах, ахуйн шавьж, мэрэгч устгах ариутгах халдваргүйжүүлэх, бохир усыг тусгай зориулалтын машинд зөөвөрлөх үйлчилгээ, нохой муур устгах, гудамж, зам талбай засварлах, үйл ажиллагааг үндсэн чиг үүргээ болгон ажиллана гэж өөрчлөх.

4.2 дахь хэсгийг Алба нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, дүүргийн Засаг даргын өмнө ажлаа тайлагнана гэж өөрчлөх.

4.3 дахь хэсгийг Алба нь нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ гэж өөрчлөх.

4.4 дэх хэсгийг Алба нь үйл ажиллагаагаа өргөтгөх, парк шинэчлэлт хийх зориулалтаар орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалтаар оруулсан хөрөнгө, албаны менежментийг боловсронгуй болгох чиглэлээр дэмжиж олгосон, дотоод гадаадын хандив, зээл тусламж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр орон нутгийн төсөв болон бусад ажил үйлчилгээний орлого, гэрээ байгуулсан ажлуудын техник хяналтын зардлаас санхүүжих зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд оролцоно гэж өөрчлөх.

4.5 дахь хэсгийг Албаны эрх, үүрэг гэж өөрчлөх.

4.5.1 дэх хэсгийг Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн

Зургаадугаар хэсэгт Байгуулах бүртгэх, өөрчлөх, татан буулгах гэснийг
Удирдлага зохион байгуулалт гэж өөрчлөх

6.1. дэх хэсгийг Албаны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, хамтын удирдлагын менежментийг нэвтрүүлэх, орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор Удирдах зөвлөл ажиллана гэж өөрчлөх.

6.2 дахь хэсгийг Удирдах зөвлөл нь Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/145 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг мөрдлөг болгон ажиллана гэж өөрчлөх.

6.3 дахь хэсгийг Албаны бүтэц, орон тооны хязгаарыг дүүргийн Засаг дарга тогтоож, албаны захирлыг томилж чөлөөлнө гэж өөрчлөх.

6.4 дэх хэсгийг Захирал нь дүүргийн Засаг даргын удирдлага дор үйл ажиллагааг явуулж, ажлын тайланг тавьж ажиллана гэж өөрчлөх.

6.5 дахь хэсгийг Захирал нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуульд заасан шалгуурыг хангасан байна гэж өөрчлөх.

6.6 дахь хэсгийг Захирал нь дүүргийн Засаг даргатай “Үр дүнгийн гэрээ” байгуулан биелэлтийг хангаж, дүгнүүлж ажиллана гэж өөрчлөх.

6.7 дахь хэсгийг Захирал нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам тогтоож мөрдүүлнэ гэж өөрчлөх.

6.8 дахь хэсгийг Захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, ажилтнуудыг томилж, чөлөөлнө гэж өөрчлөх.

6.9 дэх хэсгийг Захирал нь “Сонгинохайрхан дүүргийн захиалагчийн алба”-ыг төлөөлж гэрээ хэлцэл байгуулна гэж өөрчлөх.

Долоодугаар хэсэгт Хариуцлага гэснийг Санхүү, бүртгэл,
тайлан хяналт гэж өөрчлөх

7.1 дэх хэсгийг Алба нь санхүүгийн тайланг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргаж Аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна гэж өөрчлөх.

7.2 дахь хэсгийг Алба нь холбогдох хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын татвар төлнө гэж өөрчлөх.

7.3 дахь хэсгийг Алба нь анхан шатны нягтлан бодох бүртгэлийн баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан тэнцлийг заасан хугацаанд татварын алба бусад холбогдох байгууллагад хүргүүлнэ гэж өөрчлөх.

7.4 дэх хэсгийг Алба нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно гэж өөрчлөх.

7.5 дахь хэсгийг Алба нь өмч хөрөнгө эзэмших, ашиглах, түрээслүүлэх шилжүүлэх, худалдах устгах, хувьчлах, үнэлэх асуудлыг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ гэж өөрчлөх.

Зургаадугаар хэсэгт Байгуулах бүртгэх, өөрчлөх, татан буулгах гэснийг
Удирдлага зохион байгуулалт гэж өөрчлөх

6.1. дэх хэсгийг Албаны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, хамтын удирдлагын менежментийг нэвтрүүлэх, орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор Удирдах зөвлөл ажиллана гэж өөрчлөх.

6.2 дахь хэсгийг Удирдах зөвлөл нь Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/145 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг мөрдлөг болгон ажиллана гэж өөрчлөх.

6.3 дахь хэсгийг Албаны бүтэц, орон тооны хязгаарыг дүүргийн Засаг дарга тогтоож, албаны захирлыг томилж чөлөөлнө гэж өөрчлөх.

6.4 дэх хэсгийг Захирал нь дүүргийн Засаг даргын удирдлага дор үйл ажиллагааг явуулж, ажлын тайланг тавьж ажиллана гэж өөрчлөх.

6.5 дахь хэсгийг Захирал нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуульд заасан шалгуурыг хангасан байна гэж өөрчлөх.

6.6 дахь хэсгийг Захирал нь дүүргийн Засаг даргатай “Үр дүнгийн гэрээ” байгуулан биелэлтийг хангаж, дүгнүүлж ажиллана гэж өөрчлөх.

6.7 дахь хэсгийг Захирал нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам тогтоож мөрдүүлнэ гэж өөрчлөх.

6.8 дахь хэсгийг Захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, ажилтнуудыг томилж, чөлөөлнө гэж өөрчлөх.

6.9 дэх хэсгийг Захирал нь “Сонгинохайрхан дүүргийн захиалагчийн алба”-ыг төлөөлж гэрээ хэлцэл байгуулна гэж өөрчлөх.

Долоодугаар хэсэгт Хариуцлага гэснийг Санхүү, бүртгэл,
тайлан хяналт гэж өөрчлөх

7.1 дэх хэсгийг Алба нь санхүүгийн тайланг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргаж Аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна гэж өөрчлөх.

7.2 дахь хэсгийг Алба нь холбогдох хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын татвар төлнө гэж өөрчлөх.

7.3 дахь хэсгийг Алба нь анхан шатны нягтлан бодох бүртгэлийн баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан тэнцлийг заасан хугацаанд татварын алба бусад холбогдох байгууллагад хүргүүлнэ гэж өөрчлөх.

7.4 дэх хэсгийг Алба нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно гэж өөрчлөх.

7.5 дахь хэсгийг Алба нь өмч хөрөнгө эзэмших, ашиглах, түрээслүүлэх шилжүүлэх, худалдах устгах, хувьчлах, үнэлэх асуудлыг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ гэж өөрчлөх.

7.6 дахь хэсгийг Албаны үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллага шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар ханган ажиллана гэж өөрчлөх.

7.7 дахь хэсгийг Алба нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналтын бүтэцтэй байж болно гэж өөрчлөх.

Наймдугаар хэсэгт Бусад гэснийг Байгуулах, бүртгэх, өөрчлөх,
татан буулгах гэж өөрчлөх

8.1 дэх хэсгийг Албыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ гэж өөрчлөх.

2. Сонгинохайрхан дүүргийн “Захиалагчийн алба” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэмд дор дурдсан нэмэлтийг оруулсугай. Үүнд:

Есдүгээр бүлэгт. Хариуцлага гэж нэмэх

9.1 дэх хэсэгт Албаны захирал, ажилтнууд нь Монгол Улсын хууль тогтоомж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, дүүргийн Засаг даргын захирамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ гэж нэмэх

9.2 дахь хэсэгт Албаны захирал, ажилтнууд нь байгууллагын энэхүү дүрэм, хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн дагуу хариуцлага хүлээнэ гэж нэмэх.

Аравдугаар бүлэгт. Бусад гэж нэмэх

10.1 дэх хэсэгт Албаны дүрэмд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь энэ дүрмийн салшгүй хэсэг болно гэж нэмэх.

10.2 дахь хэсэгт Албаны дүрэм нь Монгол Улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно гэж нэмэх.